



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 17/23

Улаанбаатар хот

**Тушаал хүчингүй болгох тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Дотоод аудит, хяналт шалгалтын ажлын тайланг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний тэвийн дүрэм шинэчлэн батлагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2013 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн "Норм батлах тухай" А/524 дүгээр тушаал, 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн "Хөнгөлөлт олгох тухай" А/735 дугаар тушаал, 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Нэмэгдэл олгох тухай" А/75 дугаар тушаал, 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн "Норм шинэчлэн батлах тухай" А/534 дүгээр тушаал, 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Хүйтний нэмэгдэл олгох тухай" А/162 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Холбоо, навигаци, ажиглалтын алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны эзлжийн ажилтнуудад сар бүр олгох цай, кофе, сахарын хөнгөлөлтийн лимит, Оношлогоо, хэмжил зүйн лабораторийн ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцасны эдэлгээний нормыг тус тус шинэчлэн баталж, батлагдсан төсвийн хүрээнд захиран зарцуулахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын алба (Б.Мөнх-Очир), Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Хатанбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА